

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	4
1.1. Байгууллагын мэдээлэл	4
1.2. Төслийн танилцуулга мэдээлэл	4
1.2.1. Талбайн байршил	4
1.2.2. Ордын нөөц	5
1.3. Ил уурхайн ашиглалтын систем, үндсэн хэмжээсүүд	6
1.3.1. Ажиллах горим	7
1.4. Ил уурхайн хүчин чадал, технологи	7
1.4.1. Ил уурхайн хүчин чадал	7
1.4.2. Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж	7
1.5. 2025 оны уулын ажлын төлөвлөгөө	7
1.6. Баяжуулах үйлдвэрийн хэсэг	9
1.6.1. Баяжуулах үйлдвэрийн ажлах горим, хүчин чадал	9
1.7. Баяжуулах технологийн усны тооцоолол	10
1.8. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө	10
1.9. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	10
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	11
2.1. Байгаль орчны онцлог	11
2.2. Нийгэм эдийн засаг	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	12
3.1. Агаарын чанар	12
3.2. Хөрсөн бүрхэвч	12
3.3. Гадаргын болон газрын доорх ус	13
3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	14
3.5. Ургамлан нөмрөг	14
3.6. Амьтны аймаг	15
3.7. Нийгэм эдийн засаг	15
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	17
4.2. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	20
4.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	21
Орчны тохижилт, ногоон байгууламжын төлөвлөгөөний ажлын нийт зардал	21
4.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Орчны тохижилт, ногоон байгууламжын төлөвлөгөөний ажлын нийт зардал	22

4.5. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	22
4.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	24
4.7. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
4.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө.....	30
ДҮГНЭЛТ	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг	4
Зураг 2. Ил уурхайн гадаргуун төлөвлөлтийн дэвсгэр зураг	9
Зураг 3. Мониторингийн цэг	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг	4
Хүснэгт 2. Ордын геологийн нөөц	5
Хүснэгт 3. Ил уурхайн хажуугийн өнцгийн хэмжээ	7
Хүснэгт 4. 2025 оны уулын ажлын төлөвлөгөө	7
Хүснэгт 5. 2025 онд хэрэглэгдэх усны хэмжээ	10
Хүснэгт 6. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн төлөвлөгөө	10
Хүснэгт 7. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	10
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	16
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	17
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	20
Хүснэгт 11. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	21
Хүснэгт 12. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
Хүснэгт 13. Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	22
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	30

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
Улсын бүртгэлийн 9013001062
дугаар
Регистрийн дугаар 2550466
Хаяг Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр
Холбоо барих утас 458072

1.2. Төслийн танилцуулга мэдээлэл

1.2.1. Талбайн байршил

Төслийн талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, сумын төвөөс баруун хойш 25 км, “Шижир алт” сууринаас хойш 25 км зайд байрших ба байр зүйн М-48-126 нэрэлбэрт хамрагдана.



ЗУРАГ 1. ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг

Лицензийн дугаар MV-022859			
№	ЗУ	ХӨ	Талбайн хэмжээ, га
1	104° 40' 26.7" E	48° 23' 57.17" N	
2	104° 40' 26.76" E	48° 22' 34.08" N	
3	104° 40' 8.23" E	48° 22' 46.66" N	
4	104° 39' 49.1" E	48° 23' 0.41" N	
5	104° 39' 36.5" E	48° 23' 5.25" N	
6	104° 39' 26.47" E	48° 23' 4.4" N	

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАВААТЫН ХӨНДИЙ”-Н АЛТНЫ ШОРООН
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

7	104° 39' 23.58" E	48° 23' 0.63" N	2545.27
8	104° 39' 21.93" E	48° 22' 56.77" N	
9	104° 39' 25.54" E	48° 22' 50.9" N	
10	104° 39' 32.12" E	48° 22' 48.53" N	
11	104° 39' 40.3" E	48° 22' 49.9" N	
12	104° 40' 19.88" E	48° 22' 18.61" N	
13	104° 40' 26.7" E	48° 22' 14.16" N	
14	104° 40' 26.7" E	48° 21' 50" N	
15	104° 34' 59.04" E	48° 21' 50" N	
16	104° 34' 46.83" E	48° 23' 29.77" N	
17	104° 34' 46.87" E	48° 23' 29.83" N	
18	104° 34' 48.01" E	48° 23' 29.83" N	
19	104° 34' 48.01" E	48° 23' 31.23" N	
20	104° 35' 9.15" E	48° 23' 57.17" N	
21	104° 35' 23.59" E	48° 23' 57.17" N	
22	104° 35' 23.69" E	48° 23' 24.36" N	
23	104° 35' 34.27" E	48° 23' 24.36" N	
24	104° 35' 34.27" E	48° 23' 32.31" N	
25	104° 35' 24.25" E	48° 23' 32.31" N	
26	104° 35' 24.24" E	48° 23' 57.16" N	
27	104° 37' 49.09" E	48° 23' 57.16" N	
28	104° 37' 49.09" E	48° 23' 37.94" N	
29	104° 37' 35.09" E	48° 23' 37.94" N	
30	104° 37' 35.09" E	48° 23' 23.76" N	
31	104° 37' 47.89" E	48° 23' 23.75" N	
32	104° 37' 47.89" E	48° 23' 0.41" N	
33	104° 37' 29.97" E	48° 23' 0.41" N	
34	104° 37' 29.97" E	48° 22' 46.85" N	
35	104° 37' 38.54" E	48° 22' 46.85" N	
36	104° 37' 38.54" E	48° 22' 38.62" N	
37	104° 38' 0.02" E	48° 22' 38.62" N	
38	104° 38' 0.02" E	48° 22' 53.64" N	
39	104° 37' 52.86" E	48° 22' 53.64" N	
40	104° 37' 52.86" E	48° 23' 23.2" N	
41	104° 37' 55.57" E	48° 23' 23.2" N	
42	104° 37' 55.57" E	48° 23' 37.93" N	
43	104° 37' 53.23" E	48° 23' 37.93" N	
44	104° 37' 54.17" E	48° 23' 57.2" N	

1.2.2. Ордын нөөц

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Даваатын хөндий”-н алтны шороон ордод 2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр ордын нөөцийг бодитой /В/ зэргээр химийн цэврээр 163.72 кг алт бүхий 246.83 мянган м³ элс, боломжтой /С/ зэргээр химийн цэврээр 19.26 кг алт бүхий 27.72 мянган м³ элс, нийт 182.97 кг алт бүхий 274.55 мянган м³ элсний нөөцийг тогтоосон байна.

Хүснэгт 2. Ордын геологийн нөөц

Геологийн нөөц								
Нөөцийн хэсэглэлийн дугаар	Зузаан, м		Дундаж агуулга мг/м³	Хэсэглэлийн н талбай, мян.м²	Эзэлхүүн, мян.м³		Металлын нөөц, кг	
	хучаас	давхрага			хучаас	давхарга	шлихээр	хим.цэвэр
Дээд ашигт давхарга								
1-С'	8.4	0.7	411	5.8	48.72	3.87	1.59	1.38

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАВААТЫН ХӨНДИЙ”-Н АЛТНЫ ШОРООН
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

2-В'	6.4	0.9	249	4.24	27.16	3.61	0.9	0.78
3-С'	4.4	0.9	154	1.86	8.2	1.68	0.26	0.23
Бүгд: В+С	7.1	0.8	300	11.91	84.08	9.15	2.75	2.39
В зэрэглэлээр	6.4	0.9	249	4.24	27.16	3.61	0.9	0.78
С зэрэглэлээр	7.4	0.7	333	7.66	56.92	5.54	1.85	1.61
Доод ашигт давхарга								
1-С	30.8	1.6	365	1.13	34.72	1.8	0.66	0.57
2-В	34.2	1.6	456	3.38	115.69	5.24	2.39	2.08
3-С	37.6	1.5	553	1.55	58.36	2.33	1.29	1.12
4-С	33.4	1.2	1792	1.51	50.43	1.81	3.25	2.82
5-В	39	1.7	812	4.59	178.84	7.57	6.14	5.34
6-С	40.4	1.8	1028	1.06	42.88	1.91	1.96	1.71
7-С	45.6	1.8	1333	1	45.69	1.8	2.4	2.09
8-С	53.6	2.6	624	3.52	188.66	9.15	5.71	4.97
9-В	52.3	1.8	717	12.68	663.16	22.82	16.36	14.23
10-В	51.2	1.3	802	13.87	710.66	18.49	14.84	12.91
11-В	46.8	1.6	539	7.62	356.85	11.82	6.38	5.55
12-В	43.9	2.1	332	10.33	453.49	22.04	7.31	6.36
13-В	42.2	2.3	331	13.01	548.83	29.73	9.83	8.55
14-В	37.3	2	552	12.06	449.44	24.52	13.54	11.78
15-В	33.8	2.1	597	8.53	287.83	17.73	10.6	9.22
16-В	32.2	2	502	3.97	127.83	7.83	3.93	3.42
17-В	36.5	2.3	497	6.16	224.84	14.15	7.03	6.12
18-В	31.2	2.8	1295	11.4	355.14	32.29	41.82	36.38
19-В	28.2	2.4	2473	4.25	119.54	10.36	25.62	22.29
20-В	24.9	1.8	1605	3.56	88.45	6.54	10.5	9.13
21-В	25.5	1.8	909	6.6	168.49	12.1	11	9.57
22-С	26.2	1.7	1488	1.95	50.96	3.37	5.02	4.37
Бүгд: В+С	39.8	2	782	133.71	5320.76	265.40	207.57	180.58
В зэрэглэлээр	39.7	2	770	121.99	4849.06	243.22	187.28	162.94
С зэрэглэлээр	40.3	1.9	915	11.72	471.70	22.18	20.29	17.65
Ордын нийт								
Нийт: В+С	37.1	1.9	766	145.61	5404.84	274.55	210.31	182.97
В зэрэглэлээр	36.4	1.8	762	133.90	4876.22	246.83	188.18	163.72
С зэрэглэлээр	45.1	2.4	798	11.72	528.62	27.72	22.13	19.26

1.3. Ил уурхайн ашиглалтын систем, үндсэн хэмжээсүүд

Ордыг тээвэргүй, тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын системээр олборлоно. Тээвэртэй ашиглалтын системийн хувьд хөрсний дотоод овоолго хийх орон зай бий болох хүртэл хөрсийг тээвэрлэж гадаад овоолго үүсгэх ба дотоод овоолго байршуулах орон зай бий болсон үеэс хөрсний дотоод овоолго үүсгэж ажиллана. Тээвэргүй системийн хувьд 100% хөрсний гадаад овоолго үүсгэнэ. Элс олборлолтын ажлыг экскаватор автосамосвалын хослолоор ухаж ачин, тээвэрлэх ба олборлосон элсийг угаан баяжуулах тоног төхөөрөмжийн дэргэд байрлах элсний овоолгод буулгана.

Хөрс болон элсний давхаргын чулуулаг нь М.М.Протодьяконовын ангиллаар 1- 2 бат бөхтэй зөөлөн чулуулагт хамаарагдах учир урьдчилан буталж, сийрэгжүүлэх ажиллагаа хийгдэхгүй шууд ухаж ачна.

Догол, уурхайн хажуу:

Уулын ажлын ухалт шидэлтийг 10 м³ утгуурын багтаамжтай ЭШ 10/70 маркийн экскаватор, ухалт, ачилтыг 3 м³ утгуурын багтаамжтай Liebherr 945 маркийн экскаватор, 1.2 м³ утгуурын багтаамжтай Liebherr 924 маркийн экскаватораар тус тус хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 3. Ил уурхайн хажуугийн өнцгийн хэмжээ

Уурхайн хажуу	Дан доголын хажуугийн өнцөг	Ил уурхайн ханын хажуугийн өнцөг
Ажлын	65°	31-36°
Ажлын бус	60°	35-42°

1.3.1. Ажиллах горим

Уурхайн жилийн хүчин чадлаас хамааран уулын ажил өдөрт 2 ээлжээр явагдаж, ээлж үргэлжлэх хугацаа 12 цаг байхаар зохион байгуулах ба үүнээс ээлж хүлээлцэх, техник тоног төхөөрөмжийн үйлчилгээ, цайны цаг зэргийг хасаж тооцвол бүтээлт цаг 10 буюу 83%-ийн ээлжийн цаг ашиглалттай байхаар зохион байгуулна.

Уурхайн жилийн хүчин чадлаас хамааран уулын ажил өдөрт 2 ээлжээр явагдаж, ээлж үргэлжлэх хугацаа 12 цаг ба дулааны улиралд буюу 3-р сарын 1-ээс эхлэн уурхайн бэлтгэл ажиллуудыг хангаж, 4-р сарын 01-ээс 10-р сарыг дуустал ажиллана.

1.4. Ил уурхайн хүчин чадал, технологи

1.4.1. Ил уурхайн хүчин чадал

2025 онд 2856.96 мян.м³ хөрс хуулалт хийж 89.39 мян.м³ элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

1.4.2. Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж

Ил уурхайн үндсэн технологийн процесс нь шимт хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, тээвэртэй, тээвэргүй үндсэн хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад болон дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршуулах зэрэг байна.

1.5. 2025 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2025 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд үндсэн хөрсийг тээвэртэй, тээвэргүй ашиглалтын системээр хуулах ба тээвэртэй хөрс хуулалтын хувьд ашиглалтын эхний жилийн эхний сард гадаад овоолгод буулгаж, ашиглалтын 2 дахь сараас эхлэн хөрсний дотоод овоолго үүсгэнэ. Тээвэргүй ашиглалтын системийн хувьд 2025 оны 9-р сараас эхлэн ил уурхайн эхний 20 метрийн догол дээр шидэлт хийх ба шидэлт хийсэн хөрсийг гадаад овоолгод буулгана.


Хүснэгт 4. 2025 оны уулын ажлын төлөвлөгөө

Нөөцийн блок	Шимт хөрс хуулалт, мян.м ³	Тээвэртэй хөрс хуулалт, мян.м ³	Тээвэргүй хөрс хуулалт, мян.м ³	Элс олборлолт, мян.м ³
Дээд ашигт давхарга				
1-B'(C')	2.43	76.46	-	6.25

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАВААТЫН ХӨНДИЙ”-Н АЛТНЫ ШОРООН
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

2-B'	1.75	41.54	-	5.34
3-B'(C')	0.74	11.91	-	2.45
Доод ашигт давхарга				
8-B'(C')	-	-	-	-
9-B'	-	-	-	-
10-B'	-	-	-	-
11-B'	-	-	-	-
12-B'	-	-	-	-
13-B'	5.67	-	-	-
14-B'	5.24	9.80	331.19	-
15-B'	3.70	232.86	247.37	-
16-B'	1.72	213.09	-	-
17-B'	2.68	375.79	-	-
18-B'	4.94	591.54	-	37.08
19-B'	1.84	198.63	-	12.15
20-B'	1.54	146.51	-	8.03
21-B'	2.86	279.26	-	14.88
22-B'(C')	0.65	65.25	-	3.20

2025 онд дээрх блокуудаас нийт 2,856.96 мян.м³ хөрс хуулж, дунджаар 625.8 мг/м³ агуулгатай 89.39 мян.м³ элс олборлон баяжуулж 77.23 кг алт /химийн цэврээр/ олборлохоор байна.



ЗУРАГ 2. ИЛ УУРХАЙН ГАДАРГУУН ТӨЛӨВЛӨЛТИЙН ДЭВСГЭР ЗУРАГ

1.6. Баяжуулах үйлдвэрийн хэсэг

1.6.1. Баяжуулах үйлдвэрийн ажлах горим, хүчин чадал

Угаан баяжуулах үйлдвэр нь зөвхөн дулааны улиралд ажиллах ба 2025 онд 8-10 саруудад буюу 63-н хоног, өдрийн 12 цагийн 2 ээлжээр ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал 80 м³/цаг бол жилийн хүчин чадал нь 199.9 мян.м³ байна.

1.7. Баяжуулах технологийн усны тооцоолол

1 м³ элс угаахад 3.36 м³ технологийн ус шаардлагатайгаас 80% буюу 2.69 м³ усыг эргэлтийн усаар, 20% буюу 0.67 м³ усыг цэвэр усаар шийдвэрлэхээр тооцсон.

Хүснэгт 5. 2025 онд хэрэглэгдэх усны хэмжээ

Баяжуулах элсний хэмжээ, мян.м ³	Шаардлагатай технологийн усны хэмжээ, мян.м ³	Шаардлагатай цэвэр усны хэмжээ, мян.м ³
89.4	300.37	60.31

1.8. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

Хүснэгт 6. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 он
1	Угаан баяжуулах элс	мян.м ³	89.39
2	Элсэн дэх алтны агуулга	мг/м ³	1068.19
3	Элсэн дэх алт: Шлихээр	кг	95.49
4	Элсэн дэх алт: Химийн цэврээр	кг	83.07
Алт авалт			
5	Алт авалт	%	92.97
6	Баяжмал дахь алтны хэмжээ: Шлихээр	кг	88.78
7	Баяжмал дахь алтны хэмжээ: Химийн цэврээр	кг	77.23
Хаягдал			
8	Хаягдал дахь алт авалт	%	7.03
9	Хаягдал дахь алтны хэмжээ: Шлихээр	кг	6.71
10	Хаягдал дахь алтны хэмжээ: Химийн цэврээр	кг	5.84

1.9. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж

Хүснэгт 7. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Төрөл	Нэгж	Тоо, ш
1	Элс хүлээн авах бункер	-	м ³	1
2	Угаан баяжуулах төхөөрөмж	Скруббер 80	м ³ /цаг	1
3	Шлюз	ПГШИ-80		1
4	Сэгсрэх ширээ	СКО-0.5	м ³ /цаг	1
5	Технологийн усны насос	Д-315-50	м ³ /цаг	1
6	Цэвэр усны насос	Д-315-50	м ³ /цаг	1
7	Цэвэр усны насос	Д350-43х5	м ³ /цаг	1
8	Цэвэр усны насос	ISW200/500	м ³ /цаг	1
9	Утгуурт ачигч	SEM 655	м ³	1
10		ZL 50	м ³	1
11	Соронзон	Ердийн		Шаардлагаар
12	Бусад /ширээ, сейф, гар тэвш, хувин сав/			
13	Аналитик жин			1

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

“Хашаат Овоот Даваат” нэртэй MV-022859 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны харьяаллаар Төв аймгийн Заамар сумын нутагт Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, сумын төвөөс баруун хойш 25 км, “Шижир алт” сууринаас хойш 25 км зайд байрших ба байр зүйн зургийн М-48-126 нэрэлбэрт хамаарагдана.

Заамарын нуруу нь Туул голын баруун эрэг, талбайн төв хэсгээр орших бөгөөд 1500-1815.5 м /Цагаан уул/ үнэмлэхүй өндөртэй, уулсын хажуу нь олон тооны гол, жалгаар хэрчигдсэн, 25-300-ын налуутай /заримдаа 400/, харьцангуй өндөршилт нь 300.0-500.0 м.

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн 1-р сард агаарын хэм -370, хамгийн дулаан 7-р сард агаарын хэм +320 хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367.3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80% зун бороо байдлаар ордог. Өвөл 5-25 мм цасан бүрхүүл тогтож, хөрсний хөлдөлтийн гүн 2.0-5.0 м хүрдэг. Голчлон баруун хойноосоо 5-10 м/сек хурдтай салхилах ба зарим тохиолдолд 20 м/сек хүрдэг.

2.2. Нийгэм эдийн засаг

Төв аймгийн Заамар сум нь 2900 ам км нутаг дэвсгэртэй Монгол орны томоохон сумдын нэг юм. Анх 1959 онд байгуулагдсан ба ган зуд тохиодоггүй тул Тосон Заамар хэмээн алдаршсан байсан боловч сүүлийн үед алтны уурхай зохисгүй эрхэлснээс сумын нутаг ихэд бохирдсон байна. 1980, 90-ээд онуудад улсын тэргүүний газар тариалангийн бүс нутаг байсан байна. Заамар сум нь Тосон, Төмстэй, Хайлааст, Төв гэсэн дөрвөн багтай. Нийт 281300 га газар нутагтай, 5691 хүн амтай.

Мал аж ахуй: Заамар суманд нийт 293,356 тоо толгой мал тоологдсон ба үүнээс тэмээ 246, адуу 25051, үхэр 23165, хонь 154727, ямаа 90167 байна. Нийт малчин өрхийн тоо 729 өрх байна.

Газар тариалан: 2023 онд аймгийн дүнгээр 4119 га үр тариа, 3739 га улаан буудай, 15 га төмс, 877 га тэжээлийн ургамал, 2645 га техникийн ургамал тариалсан бол 2023 онд нийт үр тариа 11437 тонн, улаан буудай 10397 тонн, төмс 79 тонн, техникийн ургамал 1321 тонн, тэжээлийн ургамал 3174 тонн, хүнсний ногоо 101 тонн ургац хураасан байна.

Цахилгаан хангамж: Сум нь Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр дэд станцуудтай.

Зам тээвэр: Заамар сум нь бусад сум сууринтай шороон замаар холбогдох ба Улаанбаатараас баруун чиглэлд хатуу хучилтай зам өнгөрөх ба сумын төв хүртэл шороон замаар явна.

Ус хангамж: Заамарын талбай нь хөрсний болон гадаргын усны нөөц сайтай боловч ундны усны хувьд хязгаарлагдмал юм. Ус хангамжыг гүний худгаас хангадаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Элс олборлох үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм.

3.2. Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Олон салаа зам гарган зорчих
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрд ачуулах, ангилан ялгаж байх

- Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

3.3. Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбай нь Хангай-Хэнтийн гидрогеологийн мужид хамаарах бөгөөд тэжээгдлийн талбайн хэмжээ нь газрын доорх усны хуримтлалын хэмжээнээс олон дахин илүү байдаг онцлогтой. Усны илүүдэл нь гадаргын усны урсгалыг голлон тэтгэх тул талбайн гадаргын ус нь харьцангуйгаар тогтмол горимтой байдаг. Судалгааны талбайд ус агуулагч хурдасны геологи-литологи, структурын онцлог, газрын доорх усны гарал үүсэл, тэдгээрийн химийн найрлагыг харгалзан дараах уст давхарга бүрдлийг ялгадаг. Үүнд:

Дөрөвдөгчийн настай хучаас хурдасны уст бүрдэл:

- *Голын хурдасны уст бүрдэл:* Туул голын хөндий, түүний цутгалангуудаар хаа сайгүй тархсан байдаг плейстоцен, голоцены үеийн элс, хайрганцар-хайрганы болон элс, элсэнцэрээр зууралдсан бул чулуу, жижиг хэмхдэс хурдаснаас тогтоно. Ус агуулагч хурдас нь ихэнх тохиолдолд шавранцараар хучаатай байх ба зузаан нь 10 гаруй м хүрдэг. Хурдасны ус нэвчүүлэх чадвар нь харьцангуй өндөр, хувийн гарц 0.3-6.4 л/сек м, ундарга нь 18 л/сек хүрдэг. Уст давхарга нь үндсэндээ хур тунадасаар тэжээгдэнэ. Давхаргын ус нь тунгалаг, амт үнэргүй, эрдэсжилт нь 0.2-оос 1.7 г/л хүрдэг. Найрлагаараа гидрокарбонат-сульфат хлорит-натри-магнийн төрөлд хамаарагдана.
- *Делюви-пролювийн хурдасны уст давхарга:* Уулс дундын хөндийгөөр ихээхэн тархсан байх ба шаврын үе бүхий элс шавраар зууралдсан хайрганцар-хэмхдэст хурдаснаас тогтоно. Ус нэвчимтгий үеийн зузаан нь маш тогтворгүй, ойролцоогоор 10 орчим метр хүрдэг. Газрын доорхи усны түвшингийн гүн нь 2-32 м-т хэлбэлзэнэ. Ихэнхдээ хур тунадасаар тэжээгдэнэ. Голын хурдасны уст давхаргыг тэжээх юм уу, жалга судгийн булгаар усаа алддаг. Ус нэвчүүлэлт нь харьцангуй муу, хувийн гарц нь 1.75 л/сек м, ундарга нь 1-3 л/сек хүрдэг. Ус нь тунгалаг, өнгө, үнэр, амтгүй, цэнгэгээс шорвогдуу хүртэл эрдэсжилт нь 0.2-3.2 г/л. Найрлагандаа гидрокарбонат-сульфат-кальц-магнийн, заримдаа сульфат гидрокарбонат-натри-кальц-магнийн төрөлд хамаарагдана.
- *Нуур намгийн хурдасны уст давхарга:* Давхарга нь тархалт багатай, Заамарын хотгор, Цагаан нуурын хонхорын хамгийн нам хэсгүүдээр оршдог. Шавар, шавранцар, янз бүрийн ширхэглэг элс, хайрганцарын үет үеүүдээс тогтоно. Үе үе хатаж байдаг жижиг нууруудтай холбоотой, нуурууд нь шорвог, ус нь бохир, давслаг. Нууруудаас хамгийн том нь Цагаан нуур бөгөөд ус нь 3.5 г/л эрдэсжилттэй, гидрокарбонат-магни-натрийн найрлагатай юм.

Мезо-кайнозойн сэвсгэр ба хатуурсан хурдасны уст бүрдэл:

Заамарын хотгорын хэмжээнд сайн судлагдсан Хотгорын захаар ус агуулагч нь дөрөвдөгчийн уулын хормойн хурдас, доод цэрдийн хурдсууд байдаг. Газрын доорхи

усны түвшин 4-35 м хэлбэлзэх бөгөөд хотгорын төв рүү ойртох тусам түвшингийн гүн нь ихэсдэг. Усны тэжээгдэл нь холимог хур тунадас голлоно. Ус нь тунгалаг, амт үнэргүй, цэнгэгээс шорвогдуу-эрдэсжилт нь 0.3-2.2 г/л, найрлагаараа гидрокарбонат кальц-магнийн төрөлд орно.

Ан цавын ус агуулагч бүрдэл:

Энэ цогцолборууд нь венд-палеозой-мезозойн галт уулын тунамал, хувирмал болон гүний чулуулгийн ан цавжилтын бүс, газрын гадаргуугийн өндөр нам, уулын бэлийн налуу, чулуулгийн найрлага, тектоник эвдрэл зэргээс шалтгаалан уулын хярд 7 10 м-ээс бэл хөндийд 80-100 м хүртэл өөрчлөгддөг. Тектоник эвдрэлийн бүсүүдэд ус агуулагч ан цавууд 200-300 м гүнд мөрдөгддөг. Гол төлөв хурын усаар тэжээгдэх боловч түвшингийн холбоотой бусад уст цогцолборуудаас ч тэжээгдэнэ. Ус нь цэвэр тунгалаг, амт үнэргүй, эрдэсжилт нь 0.4 г/л-ээс хэтэрдэггүй, гидрокарбонат-кальц-магнийн найрлагатай. Ус нь голдуу шүүрлийн маягийн булагаар гардаг, ундарга нь 0.4-25 л/сек заримдаа 150 л/сек хүрдэг.

Төслийн талбайн хэрэгцээнд зориулж залгаа орших Их тохойролын ордын төв хэсэгт ундны зориулалтаар худаг өрөмдөж тоноглогсон болно. Техникийн болон бусад аж ахуйн хэрэгцээний усыг Туул голын усаар хангах боломжтой.

3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

3.5. Ургамлан нөмрөг

Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

3.6. Амьтны аймаг

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ховор амьтдыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгуулахын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

3.7. Нийгэм эдийн засаг

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална.

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2025 онд мэргэжлийн эрх бүхий “Маргад Очирваань” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2025 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 49,834,000 төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Зардлын хэлбэр	2025 он
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,700,000
Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
Уурхайн хаалтын зардал	-
Ногоон байгууламжийн төлөвлөгөөний зардал	800,000
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10,000,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	3,000,000
Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зардал	2,000,000
Орчны хяналт шинжилгээний зардал	5,512,000
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,050,000
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	25,772,000
НИЙТ	49,834,000

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Хүснэгт 9. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
